



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 15 өдөр

Дугаар АИМЗ

Алтай хот

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм шинэчлэн батлах тухай" 212 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны "Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм батлах тухай" 211 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Мобиком корпораци" ХХК-ийн захиалгаар баригдсан Есөнбулаг сумын Харзат багт үүрэн телефоны антенн суурилуулах 15 метр өндөр төмөр цамхагийн ажлыг хүлээн авч байнгын ашиглалтад оруулах үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	Б.Бямбадорж (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга бөгөөд аймгийн Ерөнхий архитектор)
Гишүүдэд:	З.Жаргалтуяа (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалт, хэлтсийн мэргэжилтэн)
	Б.Сүхбаатар ("ССБЭХ" ХХК-ийн захирал) (гүйцэтгэгч)
	Т.Ариунболд ("Мобиком корпораци" ХХК-ийн Говь-Алтай аймгийн бүсийн инженер)
Нарийн бичгийн дарга:	Ж.Мөнхцэцэг (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын инженерийн байгууламж хариуцсан мэргэжилтэн)

2.

2.Байгууламжийг байнгын ашиглалтад оруулахдаа гэрээнд тусгагдсаны дагуу холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, үр дүнг танилцуулахыг комисс (Б.Бямбадорж)-т үүрэг болгосугай.

3.Байгууламжийн урсгал зардлыг төсөвт тусгаж, хэвийн ажиллагааг ханган, хамгаалалтад авч ажиллахыг "Мобиком корпораци" ХХК (Д.Ариунтуяа)-д зөвлөсүгэй.

4.Үүрэн холбооны операторуудын үйл ажиллагаа, үйлчилгээний хамрах хүрээ чанарын үзүүлэлтэд тогтмол хяналт тавьж, хамтран ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Хурцгэрэл)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР